**СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/144/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын Дарга,тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Аудитор: Л.Мандахнаран<br>Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranL@audit.gov.mn<br><br>Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн Захирал: Ч.Энхчимэг<br>Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn<br><br>Аудитор: Т.Мөнхзул<br>Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/132

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Н.АМАРЖАРГАЛ ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Эрүүл Мэндийн Төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Рашаант сумын Эрүүл Мэндийн Төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. ***Үүнд:***

- Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 11 дугаар сарын 01-ны тушаалаар Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны 1-5 сард 13,966.2 мянган төгрөгийн цалинг албан хаагчдад илүү олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д "Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх

9724040272

үүрэгтэй.", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Тайлант хугацаанд 25 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 25 хоногийн хоолны зардал 80.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 116.8 мянган төгрөгөөр давсан байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 18.3 хувиар өссөн байна.

**Аудитын гол асуудал**

Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй, шатахууны илүү дутууг тооцож, хяналт тавьж ажиллаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын дарга нь сумын Засаг даргаар 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 136 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж 90.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **173,502,562.56** | **148,728,624.43** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **53,029,453.62** | **29,713,067.63** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 53,029,453.62 | 29,713,067.63 |
| **33** | **АВЛАГА** | **00.00** | **17,547,878.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 17,547,878.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **120,473,108.94** | **101,467,678.80** |
| **351** | **Түүхий эд материал** | **35,898,605.63** | **24,751,168.06** |
| 35130 | Эм боох материал | 35,898,605.63 | 24,751,168.06 |
| **354** | **Хангамжийн материал** | **84,574,503.31** | **76,716,510.74** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 806,000.00 | 806,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,876,835.00 | 1,137,207.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 77,891,668.31 | 74,773,303.24 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **465,640,468.43** | **446,176,002.88** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **465,640,468.43** | **446,176,002.88** |
| **392** | **Биет хөрөнгө** | **453,514,801.83** | **434,186,169.68** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 354,952,789.00 | 354,952,789.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -40,041,994.88 | -49,994,993.60 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 42,284,000.00 | 42,284,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -24,735,944.46 | -31,783,277.82 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 139,901,704.26 | 154,020,126.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -39,586,779.51 | -54,791,364.88 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,862,042.00 | 24,736,812.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,621,014.42 | -10,112,921.28 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,000,000.00 | 13,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,500,000.16 | -8,125,000.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **12,125,666.60** | **11,989,833.20** |
| 39301 | Програм хангамж | 407,500.00 | 407,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -135,833.40 | -271,666.80 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,854,000.00 | 11,854,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **639,143,030.99** | **594,904,627.31** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **639,143,030.99** | **594,904,627.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **639,143,030.99** | **594,904,627.31** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 243,416,874.00 | 243,416,874.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **134,288,821.33** | **90,050,417.65** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 134,288,821.33 | 134,288,821.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -44,238,403.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 261,437,335.66 | 261,437,335.66 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **639,143,030.99** | **594,904,627.31** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **763,765,892.14** | **826,349,731.92** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **101,833,272.14** | **35,439,748.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 101,833,272.14 | 35,439,748.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **661,932,620.00** | **790,909,982.99** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 659,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 659,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 41,401,700.00 | 39,026,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,401,700.00 | 39,026,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 619,871,920.00 | 751,883,982.99 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 619,871,920.00 | 751,883,982.99 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **751,959,891.41** | **870,588,135.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **751,959,891.41** | **870,588,135.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 751,959,891.41 | 870,588,135.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 405,679,918.29 | 544,164,005.32 |
| 210101 | Үндсэн цалин | 261,932,938.71 | 299,330,224.48 |
| 210102 | Нэмэгдэл | 106,086,645.30 | 190,618,483.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,241,815.58 | 4,405,811.39 |
| 210104 | Урамшуулал | 32,823,028.70 | 49,809,485.51 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,595,490.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,421,388.79 | 68,545,525.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,107,147.80 | 46,655,765.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,863,809.35 | 5,473,443.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,091,047.34 | 4,406,609.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 759,944.10 | 1,091,755.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,599,440.20 | 10,917,952.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,240,000.00 | 30,740,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,440,000.00 | 2,875,844.36 |
| 210302 | Түлш, халаалт | 25,800,000.00 | 25,504,155.64 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,360,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,540,364.00 | 54,862,619.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,585,000.00 | 2,846,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,065,000.00 | 25,714,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,069,500.00 | 1,865,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,705,200.00 | 1,155,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,115,664.00 | 3,917,571.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 19,363,748.50 |
| **2105** | **Нормативт зардал** | 129,090,031.30 | 93,322,205.37 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 113,866,026.30 | 77,150,277.87 |
| 210502 | Хоол, хүнс | 11,371,505.00 | 16,171,927.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,852,500.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 33,984,896.60 | 19,653,238.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,854,896.60 | 6,785,238.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,130,000.00 | 12,868,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,653,200.00 | 2,396,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,653,200.00 | 2,396,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,968,300.00 | 6,888,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,087,500.00 | 3,926,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,040,000.00 | 1,200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 66,000.00 | 556,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,600.00 | 55,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 37,200.00 | 37,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 313,500.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 120,000.00 | 120,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,258,500.00 | 993,250.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 50,381,792.43 | 50,015,591.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,849,200.00 | 7,751,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,532,592.43 | 42,264,191.75 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **11,806,000.73** | **-44,238,403.68** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 475,308.76 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 475,308.76 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -475,308.76 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **11,330,691.97** | **-44,238,403.68** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **721,750,720.00** | **773,362,104.99** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 59,818,100.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 59,818,100.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **661,932,620.00** | **773,362,104.99** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 659,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 659,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 41,401,700.00 | 39,026,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,401,700.00 | 39,026,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 619,871,920.00 | 734,336,104.99 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 619,871,920.00 | 734,336,104.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **656,984,938.85** | **783,178,490.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **656,984,938.85** | **783,178,490.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **656,984,938.85** | **783,178,490.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 405,679,918.29 | 544,164,005.32 |
| 210101 | Үндсэн цалин | 261,932,938.71 | 299,330,224.48 |
| 210102 | Нэмэгдэл | 106,086,645.30 | 190,618,483.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,241,815.58 | 4,405,811.39 |
| 210104 | Урамшуулал | 32,823,028.70 | 49,809,485.51 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,595,490.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,065,061.26 | 68,545,525.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,107,147.80 | 46,655,765.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,507,481.82 | 5,473,443.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,091,047.34 | 4,406,609.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 759,944.10 | 1,091,755.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,599,440.20 | 10,917,952.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,240,000.00 | 30,740,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,440,000.00 | 2,875,844.36 |
| 210302 | Түлш, халаалт | 25,800,000.00 | 25,504,155.64 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,360,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 50,130,100.00 | 37,673,650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,550,000.00 | 2,850,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,065,000.00 | 24,944,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,069,500.00 | 1,760,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 96,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,103,600.00 | 1,020,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,246,000.00 | 7,099,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 76,831,659.30 | 71,802,710.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 53,274,984.30 | 56,352,410.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 16,756,675.00 | 11,080,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,800,000.00 | 4,369,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,867,500.00 | 12,868,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 165,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,856,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,846,000.00 | 12,868,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,653,200.00 | 2,396,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,653,200.00 | 2,396,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,968,300.00 | 6,885,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,087,500.00 | 3,926,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,040,000.00 | 1,200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 66,000.00 | 556,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,600.00 | 55,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 37,200.00 | 37,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 313,500.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 120,000.00 | 120,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,258,500.00 | 990,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,549,200.00 | 8,102,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,549,200.00 | 8,102,900.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **64,765,781.15** | **-9,816,385.99** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,380,000.00** | **13,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,380,000.00** | **13,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 11,380,000.00 | 13,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,380,000.00 | 13,500,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-11,380,000.00** | **-13,500,000.00** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 53,385,781.15 | -23,316,385.99 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 53,029,453.62 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 53,029,453.62 | 29,713,067.63 |

## 2.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 243,416,874.00 | 261,437,335.66 | 122,958,129.36 | 627,812,339.02 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **243,416,874.00** | **261,437,335.66** | **122,958,129.36** | 627,812,339.02 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 11,330,691.97 | 11,330,691.97 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **243,416,874.00** | **261,437,335.66** | **134,288,821.33** | 639,143,030.99 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **243,416,874.00** | **261,437,335.66** | **134,288,821.33** | 639,143,030.99 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -44,238,403.68 | -44,238,403.68 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **243,416,874.00** | **261,437,335.66** | **90,050,417.65** | 594,904,627.31 |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 765,967,100.00 | 758,252,490.98 | 7,714,609.02 | 99% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 765,967,100.00 | 758,252,490.98 | 7,714,609.02 | 99% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 765,967,100.00 | 758,252,490.98 | 7,714,609.02 | 99% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 545,351,300.00 | 544,164,005.32 | 1,187,294.68 | 100% |
| 210101 | Үндсэн цалин | 326,303,400.00 | 299,330,224.48 | 26,973,175.52 | 92% |
| 210102 | Нэмэгдэл | 169,515,400.00 | 190,618,483.94 | (21,103,083.94) | 112% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 556,000.00 | 4,405,811.39 | (3,849,811.39) | 792% |
| 210104 | Урамшуулал | 48,976,500.00 | 49,809,485.51 | (832,985.51) | 102% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,545,800.00 | 68,545,525.66 | 274.34 | 100% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,655,800.00 | 46,655,765.20 | 34.80 | 100% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,473,500.00 | 5,473,443.46 | 56.54 | 100% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,406,700.00 | 4,406,609.22 | 90.78 | 100% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,091,800.00 | 1,091,755.16 | 44.84 | 100% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,918,000.00 | 10,917,952.62 | 47.38 | 100% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,638,400.00 | 37,673,650.00 | 1,964,750.00 | 95% |
| 210401 | Бичиг хэрэг | 2,850,000.00 | 2,850,000.00 | - | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,908,700.00 | 24,944,550.00 | 1,964,150.00 | 93% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,760,000.00 | 1,760,000.00 | - | 100% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,020,000.00 | 1,020,000.00 | - | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,099,700.00 | 7,099,100.00 | 600.00 | 100% |
| **2105** | **Нормативт зардал** | 72,256,900.00 | 71,802,710.00 | 454,190.00 | 99% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 56,806,600.00 | 56,352,410.00 | 454,190.00 | 99% |
| 210502 | Хоол, хүнс | 11,080,800.00 | 11,080,800.00 | - | 100% |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,369,500.00 | 4,369,500.00 | - | 100% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,682,000.00 | 18,682,000.00 | - | 100% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,500,000.00 | 13,500,000.00 | - | 100% |
| 210604 | Урсгал засвар | 5,182,000.00 | 5,182,000.00 | - | 100% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,396,000.00 | 2,396,000.00 | - | 100% |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,396,000.00 | 2,396,000.00 | - | 100% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,885,700.00 | 6,885,700.00 | - | 100% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,926,900.00 | 3,926,900.00 | - | 100% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 556,000.00 | 556,000.00 | - | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 55,600.00 | 55,600.00 | - | 100% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 37,200.00 | 37,200.00 | - | 100% |
| 210807 | Газрын төлбөр | 120,000.00 | 120,000.00 | - | 100% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 990,000.00 | 990,000.00 | - | 100% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,211,000.00 | 8,102,900.00 | 4,108,100.00 | 66% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,211,000.00 | 8,102,900.00 | 4,108,100.00 | 66% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 765,967,100.00 | 734,936,104.99 | 31,030,995.01 | 96% |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 600,000.00 | - | - |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 600,000.00 | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 712,937,700.00 | 734,336,104.99 | (21,398,404.99) | 103% |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 712,937,700.00 | 734,336,104.99 | (21,398,404.99) | 103% |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 53,029,400.00 | 00.00 | - | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 53,029,400.00 | 00.00 | - | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 53,029,453.62 | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 29,713,067.63 | - | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 25.00 | - | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | - | 100% |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,787.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,741.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 13,966.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 80.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 14,046.2 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 13,929.4 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Нийгмийн даатгал, цалингийн цэсийг зөрүүтэй тайлагнасан. Жирэмсний амралтаа авч байгаа эхийн ээлжийн амралтын цалинг тайлагнаагүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнээс үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээгээр шимтгэл авсан
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу бодсон.

### 3.1 Төлбөрийн акт

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 11 дугаар сарын 01-ны тушаалаар Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны 1-5 сард 13,966.2 мянган төгрөгийн цалинг албан хаагчдад илүү олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “*Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно*.”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “*Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв*

*байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.*", Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д "*Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.*", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 "*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*;" гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Томилолтын зардалтай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u>Тайлант хугацаанд 25 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 25 хоногийн хоолны зардал 80.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
<u>Өгсөн зөвлөмж:</u> Дотоод хяналт тавих хяналтаа сайжруулах

2. **Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u> Үнэгүй хүлээж авч, ашиглаж байгаа фургон автомашиныг үндсэн хөрөнгөд аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1. *Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах* үндэслэл болно гэсэнтэй нийцэхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Дээд шатны байгууллагаас шийдвэр гаргуулж бүртгэлд тусгах.

3. **Шатахууны зардалтай холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт:*</u> Тээвэр, шатахууны зардлын зарцуулалтыг нярвын тайлангаас хөөн шалгахад албан хэрэгцээнд ашиглаж байгаа автомашины жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөж, спидометрийн заалтыг тэмдэглээгүй байна. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Жишиг норм батлах тухай" журамд заасан "*Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.5-т "*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно*" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
<u>Өгсөн зөвлөмж:</u> Норм баримтлан ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн дотор, зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийгмийн даатгалын тайлан, цалингийн цэсийг зөрүүтэй тайлагнасан. | 2 | 2,742.8 | | | 2 | 2,742.8 | 2 | 2,742.8 | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зөрүүтэй байна. | 1 | 998.8 | | | 1 | 998.8 | 1 | 998.8 | | |
| **Дүн** | **3** | **3,741.6** | | | **3** | **3,741.6** | **3** | **3,741.6** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрүүл мэндийн төвийн даргын 2022.11.01 Б/24 тоот тушаалаар үндсэн цалинг нэмэгдүүлэн олгосон нь ЗГ-ын 2022 оны 107-р тогтоол, ЗГ-ын 2023 оны 241-р тогтоолтой нийцэхгүй байна. | 1 | 13,966.2 | 1 | 13,966.2 | | | | |
| Томилолтын хоолны мөнгийг 25 хүнд 80,000 төгрөгөөр давхардуулан олгосон байна. | 1 | 80.0 | | | | | 1 | 80.0 |
| Зам тээврийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын дагуу автомашины шатахууны зарцуулалтыг хөтөлж, жолоочийн тооцоог хянаж байх | 1 | | | | | | 1 | |
| Үнэгүй хүлээж авч, ашиглаж байгаа фургон автомашиныг холбогдох дээд шатны байгууллагаас шийдвэр гаргуулж, бүртгэлд тусгах. | 1 | | | | | | 1 | |
| дүн | **4** | **14,046.2** | **1** | **13,966.2** | | | **3** | **80.0** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |